



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Гадаадын магистрантурт зээлээр суралцуулах,  
тушаалд өөрчлөлт оруулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 52 дугаар тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам”, Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алтангэрэл овогтой Нямсүрэнг Улсын Ерөнхий прокурорын газрын захиалгаар Англи улсын Лондонгийн их сургуулийн Commonwealth коллежийн магистрантурт хууль зүйн чиглэлээр 2007-2008 оны хичээлийн жилээс 2 жилийн хугацаагаар Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 292 дугаар тушаалын Жүгдэр овогтой Мөнхбаатартай холбогдолтой хэсгийн “АНУ-ын Stratford их сургуулийн” гэснийг “БНСУ-ын Соганы их сургуулийн” гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 302 дугаар тушаалын Ринзаан овогтой Дэжидтэй холбогдолтой хэсгийн “АНУ-ын Стрэйер их сургуулийн” гэснийг “АНУ-ын Хойд Вирджинийн их сургуулийн Сингапур улс дахь салбар сургуулийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Н.БОЛОРМАА

Н.БОЛОРМАА

0000075